

МЭДЛЭГИЙН НИЙГЭМ ДАХЬ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИТОЙ НИЙГМИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

ROLE OF TECHNOLOGY DEVELOPED SOCIETY FOR COOPERATION OF LAW ENFORCEMENT ORGANIZATIONS IN KNOWLEDGE SOCIETY



П.ЦАЦРАЛ

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн

Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, хошууч

TSATSRAL P.

Major, Head of Social Science faculty

at Law and Social Science Institute, Law Enforcement University



Ц.БАТБАЯР

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн дэд профессор, доктор
(Ph.D), хошууч

BATBAYAR TS.

Ph.D, Major, assistant professor of Social Science faculty at Law and
Social Science Institute, Law Enforcement University

Товч агуулга: Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаанд онолын мэдлэг, мэдээлэл, мэдлэгийн үйлдвэрлэл, менежмент, үйлчилгээний гүйцэтгэх үүрэг урьд өмнө байгаагүйгээр нэмэгдэх боллоо. Орчин үеийн нийгмийн өөрчлөлтийн даяар хандлага, гол үнэт зүйлсийг хуулийн үзэл баримтлалыг боловсруулах, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахад онолын мэдлэг гэдэг утгаар ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл хууль, эрхийн мэдлэг, мэдээллийг бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах нь ухаалаг төрийн гол зорилт болоод зогсохгүй нийтийн үйлчилгээний шинэ хандлага, соёл төлөвшихөд чухал үүрэг гүйцэтгэх болов.

Abstract: Roles of knowledge of theory, information, knowledge production, management and service are more increased than before for cooperation of law enforcement organizations. It is required to use the meaning of knowledge of theory in order to improve cooperation of law enforcement organizations and to develop law concept of values, global tendency of today's social changes. On the other hand changing legal knowledge and information into production or service is the main objective of smart governance and it plays a key role in creation of new tendency and culture for public service.

Түлхүүр үгс: Мэдлэгийн нийгэм, мэдээллийн нийгэм, постмодерн нийгэм, аж үйлдвэржсэний дараах нийгэм, үйлчилгээний технологитой нийгэм, ухаалаг төр, төрийн үйлчилгээ, төр хувийн хэвшлийн түншлэл.

Key words: Knowledge society, information society, postmodern society, post-industrialized society, technology developed society, smart politics, state service, governmental and non-governmental entity.



Хууль сахиулахуй

ОРШИЛ

Судалгааны үр дүнгээр аж үйлдвэржсэний дараах нийгэм нь үйлчилгээний технологитой, мэдлэгийн нийгэм болох нь тодорхой болж ирлээ. Эл нийгмийн талаар бичигдсэн анхдагч эх сурвалжуудын хүрээнд: Ж.А.Кондорьс, Д.Рисман, К. Кларк, Р. Арон, Д.Белл¹, К.Кумар², Ф.Вебстер³, Ж.Нейсбит, Ж.Ленски, Г.Ленски⁴, В.Л.Иноземцев⁵ нарын суурь бүтээлүүдэд аж үйлдвэржсэний дараах буюу мэдээллийн нийгмийн үзэл баримтлал, орчин үеийн нийгмийн үзэл санаа, өөрчлөлт, хандлага, үнэт зүйлс, өргөн тусгагдсан байна.

Баруунд XX зууны эх гэхэд эл нийгмийн өөрчлөлтийг янз бүрийн өнцгөөс судалсан сонирхолтой өгүүлэл, ном, зохиол, үзэл баримтлал, парадигмууд гарч, тухайн нийгмийг тодорхойлсон шинэ нэр томъёо, томъёололчлоноорүүсчээ. Энэхугацаанд аж үйлдвэржсэний дараах болон мэдээллийн нийгмийн талаарх судалгаа олон чиглэлээр өргөжиж, онолын социологи, нийгмийн философийн бүх чиглэлийг хамран хөгжсөн байна. Тухайлбал, Ж.А.Кондерсын “Хүн төрөлхтний оюун ухааны түүхэн дүр зургийн эскиз”, К.Кларк. “Эдийн засгийн дэвшлийн нөхцөл” (1947-1957), Д.Рисманы “Аж үйлдвэржсэний дараах нийгэм дэх ажил эрхлэлт ба чөлөөт цаг” өгүүлэл (1958), Р.Дариндорфын “Үйлчилгээний ангийн нийгэм” өгүүлэл (1964), Капитализмын дараах нийгэм, Г.Кан, Э.Вейнер нарын “Өргөн хэрэглээний нийгэм”(1964), В.Фукс. “Үйлчилгээний эдийн засаг”(1968), А.Этционийн “Идэвхтэй нийгэм” (1968), А.Турейны “Програмчлагдсан нийгэм”,

Ж.Фурастьены “Аж үйлдвэржсэний дараах нийгэм”(1969), О.Тоффлер. “Ирээдүйн шок”(1970), З.Бжезинскийн “Технотрон эрин үе”, “Хоёр эрнийн хооронд” (1970), П.Холмосын “Хувь хүний үйлчилгээний нийгэм” (1970), М.Букчинагийн “Хомсдлын дараах нийгэм” (1970), П.Дракерын “Мэдлэгийн нийгэм” (1973), Т.Росзакын “Аж үйлдвэржсэний дараах нийгэм дэх улс төрийн дэвшил” (1972) зэрэг⁶ олон бүтээлийг нэрлэж болно.

Д.Белл өөрийн бүтээлүүдэд уг нийгмийн өөрчлөлтийн үндсэн зарчмуудыг тодорхойлсон юм⁷. Эдгээр бүтээлүүдэд тусгагдсан гол санаануудыг хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, ирээдүйн стратеги, цаашдын хөгжлийн хандлагад тусгаж, бүтээлчээр ажил хэрэг болгоход уг илтгэлийн зорилго оршиж байгаа юм. Өөрөөр хэлбэл нийгмийн өөрчлөлт хувьслын нарийн механизмуудыг онолын социологи, нийгмийн философийн зааг дээр танин мэдсэн байх нь мэдлэгийн нийгэм байгуулах үндэс болоод зогсохгүй нийгмийн өөрчлөлтийн хойноос нь хөөж хуулиа гаргадаг бус урьдчилан харж, хуулийн үзэл баримтлалаа тодорхойлох үндсэн нөхцөл бүрэлдэх юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Мэдлэгийн буюу аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай онолын үзэл баримтлалын үүсэл, хөгжлийн хандлагад дүн шинжилгээ хийж үзэхэд:

а) XX зууны II-хагасаас үйлдвэрлэлд шинжлэх ухаан, боловсролын хүч нөөц, онолын мэдлэг, оюуны технологи түүнийг хэрэгжүүлэх, бүтээх аргуудын

⁶ Иллича И. Завтай нийгэм (1973). Масуда И. Мэдээллийн нийгэм аж үйлдвэржсэний дараах нийгэм болох нь (1983), Махлуп, Умесао Т., Порат М, Стоунер Т, Катц Р нарын “Мэдээллийн нийгэм”, Френкеля.Б. Аж үйлдвэржсэний дараах үл гүйцэлдэгч үзэлтэн (1987), Фукуяма.Ф. Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн (1989), Хантингтон С. Иргэншил хоорондын мөргөлдөөн биш биз? өгүүлэл (1993), В.Л. Иноземцевийн пост-эдийн засгийн асуудлуудыг хөндөн тавьсан олон арван өгүүлэл, бүтээлүүдийг дурдаж болно.

⁷ “Капитализмын соёлын зөрчилдөөн” (1960), “Угтан ирж буй аж үйлдвэржсэний дараах нийгэм” (1973), “Мэдээллийн нийгмийн нийгмийн хүрээ” (1980) зэрэг бүтээлүүд анх хэвлэгдсэн нь аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалын хөгжилд шинэ хандлагыг бий болгосон гэж үздэг. Түүний бичсэн “Угтан ирж буй аж үйлдвэржсэний дараах нийгэм” бүтээл нь 1976, 1999 онуудад дахин хэвлэгдэж, франц, герман, япон, итали, испани, орос хэлэнд орчуулагдан гарчээ.

¹ Bell D. The coming of postindustrial society. NY.,1999, The cultural contradiction. NY.,1960.

² Kumar K. From post-industrial to post-modern society. Oxford., 2005.

³ Webster F.Theories of the information society. London and NY., 2008.

⁴ Lenski G., Lenski J. Ecological evolutionary theory. NY., 1978. Human society. NY., 2005.

⁵ Иноземцев В.Л. Постиндустриальные общества волна на западе; М., 1986. Новая технократическая волна на западе; М., 1999. Новая постиндустриальная волна на западе. М., 1999; Белл Д, Иноземцев В.Л. Эпоха разобщенности. М., 2007.

олон янз байдал бий болж, мэргэшсэн менежер, технократ, меритократ анги үүссэн.

б) Шинжлэх ухаан технологижиж, технологи шинжлэх ухаанжих харилцан хамааралтай үйл явцын үр дүнгээр шинжлэх ухааны үйлдвэрлэлийн шинэ талбарууд, мэдээлэл харилцаа холбооны технологид суурилсан оюуны үйлдвэрлэлийн бааз бий болсон

в) Технологийн дэвшлийг дагнасан мэдээллийн үйлдвэрлэлийн төрөл зүйлүүдийн хосгүй олон янз байдал бий болсноор голлон тодорхойлогдож байна.

Польш гаралтай америкийн системийн шинжээч Даниел.Белл аж үйлдвэржсэний дараах нийгмийн үндсэн шинж, суурь механизмуудыг тодорхойлохдоо нийгмийн тулгуур үйлдвэрлэл тэнхлэгээ сольж, нийгмийн үйлдвэрлэлийн материаллаг шинж өөрчлөгдөж, оюуны үйлдвэрлэлийн материаллаг бус хийсвэр хэлбэрт шилжих үйл явцыг хүмүүс хоорондын харилцааны өнөөгийн бодит байдлын дүр зурагтай зэрэгцүүлэн судалсан байна. Чингэхдээ бүхэл бүтэн зуун жилийн америкийн нийгмийн хувьсал, өөрчлөлтийг аж үйлдвэржихийн өмнөх, аж үйлдвэржсэн, аж үйлдвэржсэний дараах гэсэн нийгэм, иргэншлийн генетикийн гурван шатанд хуваан тайлбарлах үндсэн дээр гурав дахь мянганы нийгмийн өөрчлөлтийг судлах философи хандлага, арга зүйн ерөнхий суурь үндсийг тавьжээ.

Ингэснээр нийгмийн хөгжлийг авч үзэх уламжлалт философийн хандлага өөрчлөгдөж, оюуны үйлдвэрлэл, үйлчилгээ прагматизмд суурилсан хандлага эрчимтэй хөгжих болсон байна. Эл хандлагын хүрээнд онолын мэдлэг, мэдээлэл нь үйлчилгээнд төвлөрөн хөгжиж, компьютерын технологийн дэвшил нь мэргэшсэн ажилтнуудыг шаардаж буйд аж үйлдвэржсэний дараах, супер аж үйлдвэржсэн нийгмийн мөн чанарын нэгдмэл үзүүлэлтүүд тодорхойлогдож байна. Д.Белл, О.Тоффлер нар мэдлэг, мэдээлэл нь нийтэд хүртээмжтэй, хамтын баялаг болж, бодгаль хүнд төвлөрч, амин хувийн шинжтэй

болсон үзүүлэлтүүдийг гол болгож, хүн төрөлхтний нийгэм иргэншлийн хөгжлийг бусад сэтгэгчдийн адил гурван шатанд хуваасан нь ижил байгаач, шинэ шалгуур үзүүлэлтийг үндэс болгосон нь онцлог байна

Аж үйлдвэржсэний дараах нийгэмд ажлын хэлбэр нь сүлжээ, үйлдвэрлэлийн салбар нь мэдээлэл боловсруулалт, оюуны технологи нь хийсвэрлэлт, зохиомлоор бий болгох, загварчлал, онолын мэдлэгийн кодчилал болж, мэргэшсэн хөдөлмөрийн үр дүн голлох болж, уламжлалт хөдөлмөрийг шахаж, хөдөлмөрийн дараах нийгэмд шилжиж байна. Олон янзын чадвар авьяас билэгтэй хүмүүсийн нөөц оюуны үйлдвэрлэлд бүрэн хэрэгжсэнээр онолын мэдлэг шингэсэн, чанар, технологийн өндөр төвшинд боловсруулагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь өнөөгийн мэдлэгийн эдийн засгийг тодорхойлогч үзүүлэлт болсноор эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын хөгжилд шинэ ёс зүй, зан үйл, сэтгэлгээний шинэ хандлага, ертөнцийг үзэх шинэ үзэл, онол төлөвших боллоо.

Сэтгэлгээний бие даасан байдал, эрх чөлөөний бодгаль хэлбэрүүдэд шилжих болсноор барууны соёлын логик нь рациональ байдлаас иррациональ мэдрэхүйд шилжиж, соёлын хэмжүүр нь мэдрэмж, үнэлэмжийн зүйлс болж, үнэлэмж нь хүмүүс худалдан авахад бэлэн байгаа өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болсонд пост эдийн засгийн мөн чанар оршиж байна. Аж үйлдвэржсэн шатаас аж үйлдвэржсэний дараах шатанд шилжихэд үнэн болон хийсвэр зүйлийн зөрчил нь капитализм дахь соёлын зөрчилдөөний үндсэн нөхцөл болсон байна. Харин нэгдмэл тал нь зах зээл, соёл, нийгмийн бүтэц гуравын огтлолцол болж, нийгмийн бүтэц дэх дотоод шилжилтүүд нь шинэ техник, технологид суурилсан амьдралын хэв маяг, үнэт зүйлс, ертөнцийг үзэх үзлийг тодорхойлж буй шинэ үзэгдэл болжээ.

Мэдээлэл харилцааны технологи нь нийгмээрээ харилцан ярилцаж, хүн



болгоны шинэ санааг тусгаж, оновчтой шийдвэр гаргах өргөн боломжийг олгодог нь постмодерн шинжийн илэрхийлэл мөн. Үүнтэй холбоотойгоор хөгжингүй орнуудад нийгмийн хүрээний буюу иргэний нийгмийн философи асуудлууд нийгмийн философийн чухал чиглэл болон хөгжлөө. Мэдээллийн эрин үеийн мөн чанар нь хувийн болон улсын байгууллагын гадна орших, өөрсдийн сүлжээг үүсгэсэн нь харилцагч талуудын бие даасан хараат бус бүтцийг бий болгож, нийгмийн өөрчлөлтийг чанарын шинэ шатанд гаргасан нь нийгмийн хүрээний шинж байдлыг ихээхэн өөрчилж байна. Ингэж нийгмийн өөрчлөлтийн гол хандлага эрх чөлөөний хэлбэрүүдэд шилжиснээр автономит агуулга бүхий нийгмийн бүтцүүд бий болох суурийг тавьсан нь орчин үеийн нийгэм мэдлэг, мэдээлэлд тулгуурлан улам бүр боловсронгуй болох чухал хүчин зүйл болсон байна.

Аж үйлдвэржсэний дараах орнууд дэлхийн компьютерын технологийн 80.4%, оюуны өмчийн 97%-ийг эзэмшиж, мэдлэг, мэргэшил бүхий мэргэжилтнүүдийн анги үүсч, 70-80% нь мэдлэгийн эдийн засагт ажиллах болсноор хүний чадварын хөгжил, боловсрол, эрүүл мэнд нь эдгээр орнуудын хөгжлийн тулгуур хүчин зүйл болжээ. Ийнхүү философи, шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн харьцаа, уялдаа, хамаарлын асуудал хөгжлийн бодлогод голлох байр суурийг эзлэх болж байна.

Бүтээлч (креатив) аж үйлдвэрлэлийн дөрөвдөгч салбарууд үүссэнээр улс орнууд иргэдийнхээ креатив энергийг ашиглан нийгмээ нээлттэй болгохыг зорьж, бүтээлч мэргэжилтнүүд үйлдвэрлэлийн гол хүчин зүйл, нөөц болсноор өрсөлдөхүйц давуу талыг хурдтай бий болгох үндсэн нөхцөл бүрдэж, улс орнууд креатив хотуудыг бий болгох чиглэлд тэмүүлж байна. Бүтээгч хот, муж, бүсүүд гэх мэт жижиг оюуны fabriкуудад суурилсан бүтцүүд нь эдүгээ үе дэх нийгмийн өөрчлөлтийн суурь үндэс мөн. Ийм өөрчлөлт нь хүний сэтгэлгээ, ёс зүй, сэтгэл зүй, зан үйл,

араншин зэрэг философи, сэтгэл судлал, менежментийн хосолсон хандлагатай судалгааг шаардаж, ийм судалгааны ажил эрчимжих хандлагатай байна.

Технологи нь өсөн нэмэгдэж буй бүтээмжийн үндэс, нийгмийн өөрчлөлтийн чухал нөхцөл, мэргэшээгүй хөдөлмөрийг орлогч, мэргэшсэн хөдөлмөрийг улам бүр нарийсган хөгжүүлэгч механизм, шинжлэх ухааны боловсруулалтын үндэс болжээ. Ухаалаг технологи нь цаг, хүч хэмнэсэн, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой, мэдээллийг цуглуулах, ангилал, боловсруулах үүргүүдийн хамгийн боловсронгуй хувилбар, өндөр хөгжсөн уураг тархины дотоод зүй тогтолд захирагддаг нь түүний философи шинжийн илэрхийлэл мөн. Харин оюуны технологи нь онолын мэдлэг, мэдээлэл, мэдрэмжид тулгуурласан хамгийн оновчтой стратегийг тодорхойлогч болоод байна. Эдгээр технологиуд нь хүн-техник хоёрыг өөрчилж, нийгэмд технологийн шинэ соёлыг төлөвшүүлэх үндэс болохын зэрэгцээ нийгмийн өөрчлөлтийн олон хувилбарыг нөхцөлдүүлэх боллоо. Энэ бүхэн нь хүн, мэдлэг, мэдээлэл, үйлчилгээ, инноваци болон техник, технологийн философи асуудлыг тус тусад нь биш нэгдмэл уялдаатай, хүн дээр төвлөрүүлж авч үзэх шаардлагыг бий болгож байна.

Аж үйлдвэржсэний дараах нийгэмд үйлчилгээ нь үйлдвэрлэлийн тодорхой үйл ажиллагааг үйлдвэрлэлээс салгасан нь бие даасан үйлчилгээний салбар үүсэх үндэс болжээ. Үйлчилгээний салбарын өсөлтийн хурд мэдээллийг нийтийн хүртээл болгон хувирган үйлчилж, үйлчилгээг зайнаас худалдан авах, арилжаалах боломж олгож, үйлчилгээний үйлдвэрлэл нь хөдөлмөр эрхлэгчдийн тоог байнга өсөж, бүтээгдэхүүнийхээ давуу талыг товойлгон гаргахын зэрэгцээ хүний хэрэглээ, хэрэгцээг мэдэрч, түүнийг гол стратеги болгон тодорхойлдог. Гэрээ, хэлцэлд суурилсан үйлчилгээний хөдөлмөрт шилжиснээр, техник хүн хоёрын шууд харилцаа бус, хүмүүс хоорондын харилцаанд суурилж,



хүний хөдөлмөрийг техникийн механик хүчээс ялгаруулсан нь үйлчилгээний хөдөлмөрийг бүтээлч, мэргэжлийн, хувийн шинж чанартай болгосон нь эдийн засгийн нийгмийн онол (үйлчилгээний хүн) хөгжих үндэс болжээ. Чөлөөт цаг, ажлын байр, үйлдвэрлэл, хэрэглээ хоёрын зааг багасч, хөдөлмөрийн хуваарилалт нарийн төвөгтэй болж, шинжлэх ухааны багтаамж нэмэгдэж, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх үйл явц нарийсч, мэргэжсэн хөдөлмөрийг шаардах болсон зэрэг нь аж үйлдвэржсэний дараах нийгмийн хөдөлмөрийг тодорхойлогч суурь баримт болсныг судалгааны үр дүн харуулж байна. Хөдөлмөрийн шинж чанар, хөдөлмөрийн харилцааны эдгээр өөрчлөлт нь нийгмийн философийн онтологи аспект өөрчлөгдөж буйн илрэл мөн.

Мэдээлэлжсэн нийгмийн философи зарчимд ил тод, хэрэглэхэд хялбар, энгийн, орон зай, цаг хугацаа, хөрөнгө, хүчийг хэмнэсэн шуурхай, өрсөлдөөнийг хангасан, зохион байгуулалтын оновчтой инженерийн механизмыг бий болгох зэрэг хамаарна. Тусгай зарчим нь хувийн хөрөнгө оруулалт, дэмжсэн, нээлттэй, оюуны үйлдвэрлэл, нөү-хауг дэмжсэн, мэдээллийн тархалтад суурилсан эдийн засгийн даяар шинэ санаа, сонгох эрх, мэдээллийн үйлдвэрлэлийн шинэ арга, технологи, түүний компьютергүй, утасгүй хэлбэр, хүн техникт бус техник хүний хэрэглээнд дасан зохицох, мэдлэгийн тодорхой хэсгүүдийн дахин үйлдвэрлэлд суурилсан нийгмийн өөрчлөлтийн үйл явцаар тодорхойлогдож, үүрэн холбооны нийгэм уг философийн орчин үе дэх практик илрэл боллоо.

Аж үйлдвэржсэний дараах буюу мэдээлэлжсэн нийгмийн хүрээнд техник, технологи, сүлжээ, их сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүд зэрэг XXI зууны оюуны fabriкууд, тэдгээрийн гол хөдөлгөгч хүч болсон мэргэшиж, мэдээлэлжсэн, мэргэжилтэн болох бодгаль хүний тархинд ирээдүй өөрөө бүтээгдэж, үгүйсгэгдэх нөхцөл үүсээд

байна. Ийм учраас оюуны хөдөлмөрийг дэмжих, шинжлэх ухаан технологи, инновацийг тэргүүлэх чиглэл болгох нь орчин үеийн улс орнуудын хөгжлийн бодлогын үндэс болов.

Ийм нөхцөлд манай улс өөрийгөө тэтгэх, өрсөлдөх чадвартай, олон тулгуурт эдийн засагтай болохын тулд аж үйлдвэржсэний дараах буюу мэдээллийн нийгмийн онолын баримтлалын ололттой талуудыг хөгжлийн бодлогын философи үндэслэл болгон онол, практикт нэвтрүүлэх шаардлага бий болж байна. Чингэхдээ стратегийн ач холбогдол бүхий өрсөлдөх давуу талыг бий болгох боломжтой салбаруудад зөв, оновчтой хувилбараар санхүүжилт хийж, өөрийн орны соёл, боловсрол, эрүүл мэнд болон бусад нийгмийн институтууд, шинжлэх ухааны салбаруудыг дэмжих түүний бүтэц, үүргийн төрөлжсөн нарийн ялгарлыг тодорхойлох, шинэ технологи бий болгох, нутагшуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь ирээдүйн Монголын нийгмийн өөрчлөлтийг тодорхойлох үндсэн нөхцөл мөн.

Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалын олон хувилбарт дүрсүүд, постмодернизм болон бусад пост онолын чиглэлүүдийг нарийвчлан судлах нь манай нийгэм судлаач философичдын хувьд хүчээ сорих шинэ талбар бөгөөд эдүгээ үе дэх нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг танин мэдэж, судлан боловсруулах олон талт боломжийг өөртөө агуулж байна. Ялангуяа аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай философи баримтлалыг түүх, иргэншлийн философийн болон системийн хандлагаар судлах хэрэгцээ их өсч байна.

Цаашид уг баримтлалын онолын гүйцээлтийг гурав дахь мянганы нийгмийн өөрчлөлттэй уяж, улам боловсронгуй болгож, хөгжүүлэх, салбар бүрийн мэргэжилтнүүдийг эл онолын баримтлалыг өөрийн ажил, мэргэжилд бүтээлчээр хэрэгжүүлэн хөгжүүлэх, гуравдагч, дөрөвдөгч, тавдагч салбарын эрдэм шинжилгээний ажил, судалгааг өргөжүүлж, улмаар даяар



Хууль сахиулахуй

мэдээллийн зах зээл, мэдлэгийн эдийн засагт өөрийн орон зайг бий болгох, үүний тулд гаригийн онолын мэдлэг, мэдээллийн баазад мэдээлэл харилцаа холбооны технологийн тусламжтайгаар нэвтэрч, эрдэм шинжилгээ судалгааны багийг байгуулах, гадаадын мэргэжил нэгт эрдэмтэдтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх явдал мөн.

Аж үйлдвэржсэний дараах нийгэмд хүн амын тоон өсөлт нь тэдний амьдрах чадвар, мэдлэг мэдээллийн төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр онолын мэдлэг, технологи, мэдээллийн хэрэглээ эрс өсч тухайн ажил, мэргэжлийг хэрэглээ, үйлчилгээ болгох шаардлага урган гарчээ. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн үзэл баримтлал бидэнд юу авчрах вэ? гэвэл одоо явагдаж буй өөрчлөлтүүдийг тандах, уг онолын баримтлал илүү сайн онолоор солигдох нөхцөл, үйлчилгээний нийгмийн генетик мэдээллийг бий болгох нь түүний ирээдүйг улам тодруулах боломж олгох юм. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалд хийсэн философи шинжилгээний эцсийн үр дүнд уг онолын баримтлал нь хүн төвтэй хөгжлийн загварыг улам төгс болгох арга зүй, механизмыг өөртөө тээж буй явдал юм.

ДҮГНЭЛТ

Мэдээлэлжсэн нийгмийн талаарх дээрх онолын үзэл баримтлалыг хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд бүтээлчээр хэрэгжүүлэх нь бидний үндсэн зорилго мөн. Эдүгээ онолын суурь судалгааны үнэ цэнэ эрс өсөх болсноор бүх соёлт ертөнц аж үйлдвэржсэний дараах хөгжлийн замыг сонгож байхад зарим пост социалист орнууд аж үйлдвэржилтийн хойноос улайран хөөцөлдөж байгаа нь тун сонирхолтой байна.

Мэдээллийн нийгмийн үндсэн шинж нь түүний сүлжээний бүтцийн зохион байгуулалтын тэгш эрхийн зарчимтай холбоотойгоор, төвлөрөл саарч, зөрчилдөөн буурч, мэдээллийн нөлөө өсч, хөдөлмөрийн хэлбэр өөрчлөгдөж,

үндэсний мэдээллийн нөөц, иргэн-төрийн холбоо хангагдан олон нийтийн санаа бодол гол үүрэгтэй болж, эрүүл мэнд, шинжлэх ухаан, боловсролын хөгжил чанарын шинэ төвшинд хүрч, мэдлэгийн зах зээл бүрэлдэн, мэдээллийн боловсруулалт, мэдээллийн дэд бүтцийн өрсөлдөх чадвар нэмэгдэж, мэдээллийн технологийн бүх хэрэгсэл соёлыг залах болсон явдал мөн. Түүнчлэн ҮНБ-ий дийлэнх хэсэг нь мэдээллийн салбарт бүтээгдэж, мэдээллийн нөөцөөс эдийн засгийн бодит нөөцөд шилжлээ. Эдүгээ мэдээлэл нь нийтийн хэрэглээ болж, хэн ч, хэзээ ч, хаанаас ч нэвтрэх боломж бүхий мэдээллийн дэд бүтэц, зах зээл бүрэлдсэнээр нийгмийн интеграци нь нийгмийн хувьсгалыг халж, хүн болгонд ээлтэй, бидний өдөр тутмын амьдралыг баяжуулсан, шинэ мэдээллийн иргэншлийн үнэт зүйлсийг бодгаль төвшинд бий болгож, хүний танин мэдэхүйн боломжийг өргөтгөсөн зэрэг нь мэдээллийн нийгмийн гол шинж мөн.

Иймд ухаалаг төрийн үйлчилгээний үндсэн суурь нь мэдлэг, мэдээллийн салбарт бүтээгдэж, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны техникийн суурь нь мэдээлэл харилцааны технологи, түүний боловсруулах арга зүйтэй шууд холбогдон ирээдүйн стратегия тодорхойлох шаардлага нэгэнт буй болсон байна. Үүнийг соргоогоор тусгаж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, түүнийг тасралтгүй шинэ мэдлэг-технологииор хөгжүүлж, үндэсний хууль сахиулах байгууллагуудын өндөр нууцлалтай нэгдсэн сүлжээг буй болгоход шинэ мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх шаардлага тулгарч байна.

Мөн хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд ХСИС нь инновацийн төв нь болж, шинж мэдлэг-технологииудыг бүтээж инкубаторт оруулан ургуулж байдаг үндсэн нэгж байх ёстойг мэдлэгийн нийгмийн тухай үзэл баримтлал бидэнд хэлж өгч

байна. Төрийн үйлчилгээг төрөлжүүлж, хөгжүүлэхэд ч уг онолын үзэл баримтлал чухал үүрэг гүйцэтгэх болно. Орчин үеийн болон орчин үеийн дараах үеийн нийгмийн өөрчлөлт хандлагуудыг хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд мэдрэмжтэйгээр нэвтрүүлэх шаардлага нь тулгамдаж буй асуудал болж байна.

Ухаалаг төрийн онолын үзэл баримтлал нь өргөн утгаараа онолын мэдлэг, мэдээлэл, үйлчилгээнд суурилсан мэдээлэлжсэн нийгмийн үзэл баримтлал мөн бөгөөд манай хууль сахиулах байгууллагуудын хамтын үйл ажиллагааны гол функцийг гүйцэтгэх нь ч байгаа.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

а) Монгол хэл дээр

1.Ц.Батбаяр. Аж үйлдвэржсэний дараах нийгэм үйлчилгээний технологитой нийгэм болох нь: Нийтийн үйлчилгээ. УБ., 2014.

2.Ц.Батбаяр. XXI зуун дахь мэдээлэлжсэн нийгэм байгуулах тухай Женев болон Тунисийн тунхаглалын зарчим. УБ., 2014.

3.Ц.Батбаяр. Сэтгэлгээний түүх, соёл. УБ., 2014.

4.Ц.Батбаяр. Социологи. УБ., 2015.

5.П.Дракер. XXI зууны менежментийн үүрэг ба сорилт. УБ., 2012. (Орч Ц.Цэрэндорж нар)

б) Орос хэл дээр

1.Алексеев П.В. Социальная философия. М., 2003.

2.Белл Д. Грядущее постиндустриальное общество. М., 1998.

3.Белл Д., Иноземцев В.Л. Эпоха разобщенности. М., 2007.

4.Ц.Батбаяр. "Информационное общество и его реальное состояние в современной Монголии". "Философия, социология, политология, культурология". № 14. Улан-Уде, 2012.

5.Гнедовский В.М. Проблемы развития постиндустриального общества в городах США. УДК 316.324.8, ББК 71.4(3). М., 2012.

6.Драч Г.В., Матяш Т.П. Культурология. Ростов-на-Дону, 2001.

7.Дракер П.Ф. Посткапиталистическое общество. М., 1999.

8.Д.Дашпүрэв. Этапы модернизации современного монгольского общества:

социально-философский анализ. М., 1995.

9.Д.Дашпүрэв. Диалектика соотношения теории и практики в условиях социализма. М., 1997.

10.Дынкина А.А. Мировая экономика: прогноз до 2020 года. М., 2007.

11.Ермолаев С.А. Разруха в академических головах. Почему капиталистическое общество не может быть постиндустриальным. М., 2008.

12.Кеван К. Революция услуг в мировой экономике. М., 2007.

13.Кузьмин Е.И., Фирсов В.Р. Формирование информационного общества в XXI веке. СПб., 2006.

14.Иванов Д.В. Виртуализация общества. М., 2002.

15.Иванов Д.В. Эволюция концепции глобализации //Телескоп. №5. М., 2002.

16.Иноземцев В.Л. Капитализм, социализм или постиндустриальное общество? Коммунист. № 4. М., 1991.

17.Иноземцев В.Л. Расколота цивилизация наличествующей предпосылки и возможные последствия постэкономической революции. М., 1999.

18.Иноземцев В.Л. Вестернизация как глобализация и "глобализация" как американизация. Вопросы Философии. № 4. М., 2004.

19.Кеван К. Революция услуг в мировой экономике. М., 2007.

20.Лашенов А.Н. Аналитика постиндустриального общества: от кибернетических к социологическим теориям. М., 2012.

21.Манакова И.Ю. Методологические аспекты исследования постиндустриального общества. Вестник ВГУ. Серия: Философия, УДК 02.41.11. М., 2011.

22.Никитская Н. Миф о постиндустриальном обществе. М., 2012.

23.Панарин И.Н. Технология информационной войны. М., 2007.

24.Розин В.М. Философия техники. М., 2001.

25.Тузовский И.Д. Светлое завтра? Антиутопияфутурологии и футурология антиутопии. Челябинск, 2009.

26.С.Төмөр-Очир. Научно-обоснованное применение выборочного метода как одна из важнейших условий повышения эффективности и качества конкретно-социологических исследований. УБ., 1982.

27.Ц.Цэцэнбилэг. Проблемы модернизации монгольского общества.

УБ., 2002.

28. Г. Сайнхишиг. Общие закономерности и особенности возникновения и развития социализма в Монгольской Народной Республике. М., 1979.

29. Г. Чулуунбаатар. Монгольский вариант восточного пути развития: В поисках новых теоретико-методологических подходов. М., 1993.

30. Юзвшин И.И. Основы информатиологии. М., 2001.

31. Яковец Ю.В. Формирование постиндустриальной парадигмы: истоки и перспективы. Вопросы Философии. №1. М., 1997.

32. Якунин В.И. и др., Постиндустриализм: опыт критического анализа. М., 2012.

в) Англи хэл дээр хэвлэгдсэн судалгааны бүтээлүүд:

1. Andrew M. *Information technology law*. First published Oxford University press, 2010.

2. Bell D. *The Social Framework of the Information Society*. Oxford University press, 1980.

3. Bell D. Kristol L. *The Crisis in Economic theory*. NY, 1981.

4. Bell D. *The End of Ideology*. Cambridge. (Mass.) – London, 1986.

5. Bell D. *The World and the United States in 2013*. NY, 1987.

6. Bell D. *Criticism of Post – industrial society*. NY, 1992.

7. Bell D. *The coming of post-industrial society*. A. Venture in social forecasting N.Y., 1999.

8. Castells M. *Working-Class Network Society: Communication Technology and information Have-less in Urban China*. NY, 2009.

9. Castells M. *The Rise of the Network Society: The Information Age: Economy, Society and Culture*. Volume 1. Malden: Blackwell. Second Edition. NY, 2009.

10. Castells M. *The Power of identity: The Information Age: Economy, Society and Culture*. Volume 2. Malden: Blackwell. Second Edition. NY, 2011.

11. Heylighen F. *World Futures: the journal of General Evolution*. № 45. NY, 1995.

12. Efrén N. *Perspective on Urban society: Preindustrial to Postindustrial*. NY, 2008.

13. Fuchs C. *Internet and society: Social theory in the information age*. NY, 2008.

14. Florida R. *Creative class war*. Washington, 2004.

15. Florida R. *The rise of the creative class*. NY, 2002.

16. Lenski G. *Ecological evolutionary theory*. NY, 2005.

17. Lucas P. Ballay J. *Trillions: Triving in the Emerging information ecology*. NY, 2012.

18. Kumar K. *From post-industrial to Postmodern-society*. Blackwell Publishing, 2005.

19. Kotkin J. *Paths to property*. American enterprise. 2003.

20. Masuda Yoneji. *The information society as postindustrial society*. NY, 1981.

21. Naisbitt J. *Megatrend*. NY, 1982.

22. Toffler A. *The third wave*. NY, 1981.

23. Toffler A. *Powershift: Knowledge, Wealth and Violence at the age of the 21st Century*. NY, 1990.



МОНГОЛЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, доктор, цагдаагийн дэд хурандаа
Ш.Ариунбилэг